

САЙДЫН ТУШААЛЫН ТӨСӨЛ

Журам батлах тухай

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/-т үүрэг болгосугай.

3.Тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн захирлуудад даалгасугай.

4.Энэ тушаал баталсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/251 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.ЧИНЗОРИГ

ТАНИЛЦУУЛГА

“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам”-ын төслийн тухай

Чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд шилжиж байгаа өнөө үед багш нарын мэдлэг чадвар, мэргэшил аргазүйн чадавхийг дээшлүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал асуудлын нэг нь багшийн сургалтын ажлын ачааллыг тогтоох, цалин хөлсийг бодитоор тооцох явдал юм.

Сангийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 289/А375 дугаар тушаалаар хамтран баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбогдон энэхүү журмыг шинэчлэх шаардлага бий болсон.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, багшийн нэмэгдэл хөлс, ажлын ачааллыг шинэчлэх зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан “МБСБ-ын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох, сургалтын цагийн ачааллыг тогтоох шинэчилсэн журмын төсөл боловсруулах” ажлын хэсгийг 2019 оны А/73 тоот тушаалаар байгуулан ажилласан болно.

Ажлын хэсэг мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-т Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын онолын болон дадлагын багшийн сургалтын цагийн ачаалал, цалин хөлс, амралтын хоног нь адил тэгш байна гэж заасны дагуу мэргэжлийн болон ерөнхий эрдмийн багшийн жилийн цагийн ачаалал ижил 20 багц цаг байх, багшийн карьер хөгжлийг дэмжих, багшийн шинэ санаа, бүтээл инноваци бий болгох багш сургалтын байгууллага хамтдаа хөгжих нөхцлийг бүрдүүлэх холбогдох өөрчлөлтийг хийсэн.

Журмын шинэчилсэн төсөл боловсруулахтай холбогдуулан Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн багш нараас санал авч ажлын хэсгийн хэлэлцүүлгийг 3 удаа зохион байгуулан холбогдох өөрчлөлтийг оруулан 2020 оны 3 дугаар сарын 9-ны өдөр Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд, МБС-ын ҮМАЗТ, МБСБХЗГ-ын мэргэжилтүүдэд цахимаар хүргүүлэн санал авч тусгасан.

Журамд багшийн ур чадварын түвшин, ажил мэргэжлээрээ өсөн дэвжих нөхцөл, сургуулийн болон сургалтын үйл ажиллагааг дэмжсэн бүтээлч үйл ажиллагаа, багшийн ажлын үнэлгээ, сургалтын цагийн ачаалал зэрэг олон талт хамаарлыг уялдуулж сургалтын цагийн ачааллыг тогтоосон.

Мөн МБСБ-ын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журамд сургууль дээрх онол, дадлагын 45 цагийн бодит гүйцэтгэлийг нэг багц цаг гэж тооцож байсныг 36 цагийг нэг багц цаг гэж өөрчилсөнтэй холбогдуулан мастер, ахлах, багш, дадлагажуулагч багшийн танхимын сургалтын жилийн ачааллыг тус бүр 1 багц цагаар нэмэгдүүлж, танхимын бус багц цагийн ачааллыг 1 багц цагаар

бууруулсан.

Ингэснээр багшийн сургалтын долоо хоногийн цагийн ачаалал 2,5 жилийн сургалтад 21 цагаас 18 цаг, техникийн боловсролд 25 цагаас 20 цаг болж ачаалал буурч байна.

Мастер багш, ахлах багш, багш, дадлагажигч багшид тавигдах шаардлага шалгуурыг хэмжигдэхүйц, тодорхой, бодитой үнэлж болохуйц тодорхойлж, багшийн мэргэжлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлттэй шууд хамааралгүй болгон өөрчилж, шалгуурыг заавал хангасан байх зохицуулалтыг тусгасан.

Багшийн ур чадварын түвшинг тогтоохтой холбогдсон 2 дахь шатлал шалгуур үзүүлэлтийг журамд шинээр тусгаж мэргэжлийн мэдлэг, ур чадварыг шалгалтаар, сургалт заах арга зүй, судалгаа, инновацийг нотлох баримтад тулгуурлан үнэлэхээр өөрчлөлт хийсэн.

Ийнхүү багшийн ур чадварын түвшинээс хамааруулан сургалтын цагийн ачааллыг тогтоосноор багшийн карьер хөгжлийг дэмжин багшийн үйл ажиллагаа, үнэлгээг бодитой болгон багш суралцагчтайгаа илүү их хамтран ажиллаж, ур чадвартай ажилтан бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН БАГШИЙН СУРГАЛТЫН ЦАГИЙН АЧААЛЛЫГ
ТОГТООХ, ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын цагийн ачааллыг багшийн ур чадварын түвшинтэй уялдуулан тогтоох, тооцоход энэхүү журмыг баримтална.
- 1.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад үндсэн орон тоонд ажиллаж байгаа мастер багш, ахлах багш, багш, дадлагажигч багшийн ур чадварын түвшин тогтоох, ахиулах, бууруулах, сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3 Ур чадварын түвшин, сургалтын цагийн ачааллыг тогтоох үйл ажиллагаа нь үнэн зөв, бодитой, тодорхой, судалгаа, нотолгоонд тулгуурласан, хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.
- 1.4 Багшийн ур чадварын түвшингээс хамааруулан сургалтын цагийн ачаалал болон нэг багцад ногдох нэмэгдэл хөлсийг ялгавартай тогтооно.

Хоёр. Багшийн ур чадварын түвшин, түүнд тавигдах ерөнхий шаардлага

- 2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн багш нь ур чадварын хувьд мастер багш, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 4, ерөнхий эрдмийн багш нь ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 3 түвшинтэй байна.
- 2.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мастер багш нь дараах шаардлагыг хангасан байна:
 - 2.2.1 Эзэмшсэн мэргэжлээрээ магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
 - 2.2.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 12-аас доошгүй, үйлдвэрлэл дээр 3-аас дээш жил ажилласан, эсхүл үйлдвэрлэлийн дадлагыг 3-аас дээш жил үр дүнтэй удирдсан, мэргэжлийн өндөр зэрэг, ур чадвартай байх;
 - 2.2.3 Мэргэжлийн боловсрол, сургалт. “Ерөнхий шаардлага” стандарт MNS 6541:2015 боловсруулахад оролцсон байх, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулан түгээн дэлгэрүүлсэн байх;
 - 2.2.4 Шинэ техник, технологи, инновацийг сургалтад нэвтрүүлж, үр дүн гарсан байх;
 - 2.2.5 Салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн ном, сурах бичиг, иж бүрэн цахим хичээл бүтээж, сургалтад ашигласан байх;

- 2.2.6 Судалгаа шинжилгээний ажил эрхэлж, гадаад, дотоодын мэргэжлийн ном сэтгүүлд нийтлүүлсэн байх;
 - 2.2.7 Олон улс, улс, бүсийн мэргэжлийн ур чадварын уралдаанд өөрөө болон шавь нь шагналт байранд шалгарсан байх;
 - 2.2.8 Сургалтын шинэ технологи, арга зүйг нэвтрүүлэн салбарын хэмжээнд туршлага болсон байх;
 - 2.2.9 Шинэ технологи, мэргэжил, арга зүйн удирдлагаар 8-аас доошгүй багшид зөвлөн тусалж, мэргэжлийн болон багшлах ур чадварт сургасан байх;
 - 2.2.10 Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 40-иас доошгүй хувьтай байх;
 - 2.2.11 Багшийн ёс зүйн зөрчилгүй байх;
- 2.3 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын ахлах багш нь дараах шаардлагыг хангасан байна:
- 2.3.1 Магистр, түүнээс дээш зэрэгтэй;
 - 2.3.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 8-аас доошгүй жил, үйлдвэрлэл дээр 2-оос дээш жил ажилласан эсхүл үйлдвэрлэлийн дадлагыг 2-оос дээш жил үр дүнтэй удирдсан, мэргэжлийн өндөр зэрэг, ур чадвартай байх (Ерөнхий эрдмийн багш нь боловсролын салбарт 10-оос доошгүй жил ажилласан байх);
 - 2.3.3 Мэргэжлийн боловсрол, сургалт. “Ерөнхий шаардлага” стандарт MNS 6541:2015 боловсруулахад оролцсон байх, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад сургууль, бүсийн хэмжээнд оролцсон байх (Ерөнхий эрдмийн багш нь цөм хөтөлбөрт нийцүүлэн хөтөлбөрийн боловсруулалтыг иж бүрэн хийсэн байх);
 - 2.3.4 Шинэ техник, технологи, инновацийг сургалтад ашигласан байх;
 - 2.3.5 Сурах бичиг, иж бүрэн цахим хичээл, гарын авлага бичиж сургалтад бүтээлчээр ашигласан байх;
 - 2.3.6 Судалгааны ажил хийж, бүс, орон нутаг, сургуулийн хурлаар хэлэлцүүлсэн байх;
 - 2.3.7 Улс, бүс, аймаг, орон нутгийн мэргэжлийн ур чадварын уралдаан, тэмцээн, олимпиадад өөрөө болон шавь нь шагналт байранд шалгарсан байх;
 - 2.3.8 Суралцагчийн хөгжилд гарсан ахиц дэвшлийг оношлох, үнэлэх, түүний үр дүнд үндэслэн сургалтын чанарыг дээшлүүлсэн байх;
 - 2.3.9 Шинэ технологи, мэргэжил, арга зүйн удирдлагаар 5-аас доошгүй багшид зөвлөн тусалж, мэргэжлийн болон багшлах ур чадварт сургасан байх;
 - 2.3.10 Мэргэжлийн болон удирдсан ангийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 35-аас доошгүй хувьтай байх;
 - 2.3.11 Багшийн ёс зүйн зөрчилгүй байх;

2.4 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нь дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1 Эзэмшсэн мэргэжлээрээ бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байх;

2.4.2 Дадлагажигч багшаар 1-ээс доошгүй жил ажилласан байх;

2.4.3 Сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэн сайжруулахад сургуулийн хэмжээнд оролцсон, сургалтад ашигласан байх;

2.4.4 Гарын авлага, зөвлөмж бичиж сургалтад ашигласан байх;

2.4.5 Судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг байх;

2.4.6 Суралцагчийн хөгжилд гарсан ахиц дэвшлийг оношлох, үнэлэх, түүний үр дүнд үндэслэн сургалтын чанарыг дээшлүүлсэн байх;

2.4.7 Бие даан өөрийгөө хөгжүүлж, мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж, тодорхой ахиц гаргасан байх;

2.4.8 Мэргэжлийн болон удирдсан ангийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 30-аас доошгүй хувьтай байх;

2.4.9 Багшийн ёс зүйн зөрчилгүй байх;

2.5 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дадлагажигч багш нь дараах шаардлагыг хангасан байна:

2.5.1 Эзэмшсэн мэргэжлээрээ бакалавр зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай мэргэжлийн өндөр зэрэгтэй байх;

2.5.2 Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, ашиглах арга зүйн талаар судалж, суралцсан байх, (ерөнхий эрдмийн багш нь жишиг цөм хөтөлбөрийн хүрээнд заавал судлах агуулгыг судалсан байх);

2.5.3 Туршлагатай багшийн удирдлага зөвлөмжөөр сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт явуулж, үнэлгээ хийх чадвартай байх;

2.5.4 Харилцааны болон багаар ажиллах ур чадвар эзэмшсэн байх;

2.5.5 Багшийн ёс зүйн зөрчилгүй байх;

Гурав. Багшийн ур чадварын түвшин тогтоох ажлыг зохион байгуулах

3.1 Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын захиргаа нь ажлын хэсгийг байгуулан ур чадварын түвшинг тогтоож, захирлын тушаалаар баталгаажуулна.

3.2 Багшийн ур чадварын түвшинг 3 жил тутамд тогтооно.

3.3 Багшийн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарч сургуулийн захиргаа багшийн ур чадварын түвшинг тогтоох, ахиулах, бууруулах ажлыг хугацаа харгалзахгүйгээр зохион байгуулж болно.

3.4 Энэхүү журмын 2-т заасан ерөнхий шаардлагыг бүрэн хангасан багш доорх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээнд хамрагдаж, 75-аас дээш оноо авсан тохиолдолд тухайн түвшинг хангасанд тооцно.

№	Шалгуур үзүүлэлт	Харгалзах оноо
1	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар	60
2	Сургалт заах арга зүй, судалгаа, инноваци	40
	Нийт дүн	100

3.5 Мэргэжлийн мэдлэг, ур чадварын шалгуур үзүүлэлтийн харгалзах онооны 50% нь мэргэжлийн ур чадвар, 30% нь мэргэжлийн онолын мэдлэг, 20% нь гадаад хэл (мэргэжлийн), мэдээллийн технологийн шалгалтын агуулга байна.

3.6 Сургалт заах арга зүй, судалгаа инноваци гэсэн шалгуур үзүүлэлтийг сургалтын байгууллага тусгай үзүүлэлт боловсруулж, баримт нотолгоонд тулгуурлан үнэлнэ.

3.7 Сургалт заах арга зүй, судалгаа инноваци гэсэн шалгуур үзүүлэлтэд сурлагын амжилтын ахиц, хөндлөнгийн шалгалт, суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг заавал багтаасан байна.

Дөрөв. Багшийн сургалтын цагийн ачаалал тогтоох

4.1 Сангийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 289/А375 дугаар тушаалаар хамтран баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам”-ыг баримтална.

4.2 Багшийн жилийн сургалтын танхимын болон танхимын бус багц цагийн ачааллыг ур чадварын түвшингээс хамааруулан дараах хүснэгтэд зааснаар дагаж мөрдөнө.

Багшийн ур чадварын түвшин	Танхимын сургалтын багц цаг		Танхимын бус сургалтын багц цаг	
	Эзлэх хувь	Жилийн ачааллын багц цаг	Эзлэх хувь	Жилийн ачааллын багц цаг
Мастер багш	80%	16	20%	4
Ахлах багш	85%	17	15%	3
Багш	90%	18	10%	2
Дадлагажигч багш	95%	19	5%	1